



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/32/НА-СТА-ТШЗ**

<p>Баянхонгор 2022 он Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: <a href="mailto:bunchinsuren@audit.gov.mn">bunchinsuren@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Төлбөрийн акт .....	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БӨМБӨГӨР СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ТАЙВАНЖАРГАЛ  
ТАНАА

№ 2/110

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke, is written over a red rectangular stamp. The stamp contains some illegible text and a central emblem.

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,574,086.03</b>	<b>48,976,814.98</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	41,253.03	50,181.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	41,253.03	50,181.98
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>35,532,833.00</b>	<b>48,926,633.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,772,333.00</b>	<b>6,772,333.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	6,772,333.00	6,772,333.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	21,680,000.00	12,247,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>5,878,000.00</b>	<b>29,906,800.00</b>
35410	Бичиг хэргийн материал	292,000.00	292,000.00
35420	Аж ахуйн материал	4,251,000.00	24,259,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,335,000.00	5,355,200.00
35600	Мал амьтад	1,202,500.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,086,827,538.85</b>	<b>1,088,424,507.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,086,827,538.85</b>	<b>1,088,424,507.99</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,065,024,038.77</b>	<b>1,066,031,841.28</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,075,973,431.51	1,148,291,802.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-292,564,442.74	-335,932,697.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,006,390.30	197,006,390.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-139,305,074.04	-166,874,482.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,993,825.98	320,427,925.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-218,487,962.39	-239,195,156.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,220,955.00	69,646,955.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,853,317.18	-43,475,728.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	126,424,914.19	126,424,914.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,214,481.86	-12,117,883.46
39217	Ном	1,829,800.00	1,829,800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,803,500.08</b>	<b>22,392,666.71</b>
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-312,500.00	-437,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,466,000.00	29,501,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-4,099,999.92	-7,420,833.29
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,122,401,624.88</b>	<b>1,137,401,322.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>72,112.00</b>	<b>108,569.97</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>72,112.00</b>	<b>108,569.97</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>72,112.00</b>	<b>108,569.97</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	36,457.97
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>72,112.00</b>	<b>72,112.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	72,112.00	72,112.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,122,329,512.88</b>	<b>1,137,292,753.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,122,329,512.88</b>	<b>1,137,292,753.00</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	525,196,220.52	525,196,220.52
51101	Өмч: - төрийн	525,196,220.52	525,196,220.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>22,862,752.17</b>	<b>37,825,992.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	22,862,752.17	22,862,752.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	14,963,240.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	574,270,540.19	574,270,540.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,122,401,624.88</b>	<b>1,137,401,322.97</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>607,037,537.19</b>	<b>633,707,616.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>174,875,434.19</b>	<b>116,838,471.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>174,875,434.19</b>	<b>116,838,471.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	174,875,434.19	350,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	570,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	174,305,434.19	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		86,252,471.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		30,236,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>432,162,103.00</b>	<b>516,869,145.54</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,580,103.00</b>	<b>113,443,545.54</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,580,103.00	113,443,545.54
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>379,582,000.00</b>	<b>403,425,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,582,000.00	403,425,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>563,546,051.40</b>	<b>618,744,376.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>563,546,051.40</b>	<b>618,744,376.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>524,133,963.45</b>	<b>559,249,677.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>229,150,119.56</b>	<b>238,923,973.00</b>
210101	Үндсэн цалин	229,150,119.56	238,923,973.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,987,813.47</b>	<b>31,846,613.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,640,388.95	21,503,134.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,454,981.13	2,389,240.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,837,984.90	1,911,392.00
210204	Ажилгүйдлийн даатгал	459,495.23	477,848.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,594,963.26	5,564,998.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,363,453.00</b>	<b>18,979,648.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,614,603.00	3,597,512.00
210302	Түлш, халаалт	15,748,850.00	15,382,136.06
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,296,758.00</b>	<b>38,411,907.00</b>
210401	Бичиг хэрэг	4,564,200.00	4,285,613.00
210402	Тээвэр, шатахуун	24,447,158.00	25,751,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	485,200.00	2,809,387.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	3,707,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	430,000.00	655,677.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,464,700.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	11,905,500.00	1,202,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>300,000.00</b>	<b>180,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	180,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,774,000.00</b>	<b>5,880,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,784,000.00	5,880,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,990,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>49,675,076.00</b>	<b>59,891,035.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,727,876.00	58,571,535.00

**Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	88,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,765,200.00	891,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>138,586,743.42</b>	<b>165,136,001.86</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,244,900.00	53,519,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,147,400.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,194,443.42	111,616,501.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,412,087.95</b>	<b>59,494,698.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,326,500.00</b>	<b>1,250,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,126,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	1,250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>31,085,587.95</b>	<b>58,244,698.43</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	360,173.95	187,147.89
213404	Хөрөнгийн	30,725,414.00	58,057,550.54
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>43,491,485.79</b>	<b>14,963,240.12</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>43,491,485.79</b>	<b>14,963,240.12</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>432,732,103.00</b>	<b>517,219,145.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>570,000.00</b>	<b>350,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>570,000.00</b>	<b>350,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>570,000.00</b>	<b>350,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	570,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>432,162,103.00</b>	<b>516,869,145.54</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,580,103.00</b>	<b>113,443,545.54</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,580,103.00	113,443,545.54
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>379,582,000.00</b>	<b>403,425,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	379,582,000.00	403,425,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>401,662,103.00</b>	<b>490,258,145.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>401,662,103.00</b>	<b>490,258,145.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>362,250,015.05</b>	<b>430,763,447.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>225,767,673.05</b>	<b>238,125,857.05</b>
210101	Үндсэн цалин	213,494,073.05	188,505,800.00
210102	Нэмэгдэл	00.00	33,180,749.05
210105	Гэрээт ажлын хөлс	12,273,600.00	16,439,308.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,681,200.00</b>	<b>32,617,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,997,800.00	22,952,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,420,900.00	2,416,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,936,700.00	1,932,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	484,200.00	483,300.00

**Бөмбөгөр сумын ЭДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	4,841,600.00	4,832,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,842,628.00</b>	<b>18,863,125.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,087,481.00	3,045,300.00
210302	Түлш, халаалт	15,755,147.00	15,817,825.06
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,927,625.00</b>	<b>38,465,170.00</b>
210401	Бичиг хэрэг	3,750,500.00	3,428,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,025,500.00	23,940,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,191,625.00	1,136,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	9,359,990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>5,200,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	5,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,040,000.00</b>	<b>4,185,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,020,000.00	990,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	180,000.00
210604	Урсгал засвар	20,000.00	3,014,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,174,000.00</b>	<b>5,880,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,784,000.00	5,880,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,390,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>32,256,089.00</b>	<b>59,961,495.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,134,089.00	55,968,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	218,000.00	88,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,560,800.00</b>	<b>27,465,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,610,800.00	26,465,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,412,087.95</b>	<b>59,494,698.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,326,500.00</b>	<b>1,250,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,126,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	1,250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>31,085,587.95</b>	<b>58,244,698.43</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	360,173.95	187,147.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>31,070,000.00</b>	<b>26,961,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>31,070,000.00</b>	<b>26,961,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>31,070,000.00</b>	<b>26,961,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>31,070,000.00</b>	<b>26,961,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,070,000.00	26,961,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-31,070,000.00</b>	<b>-26,961,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	595,501,364.19	-41,859,533.63	1,078,838,051.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	21,230,824.00	21,230,824.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,196,220.52	595,501,364.19	-20,628,709.63	1,100,068,875.08
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	00.00	-21,230,824.00	00.00	-21,230,824.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	43,491,461.80	43,491,461.80
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	22,862,752.17	1,122,329,512.88
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	22,862,752.17	1,122,329,512.88
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	22,862,752.17	1,122,329,512.88
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,998,255.74	14,998,255.74
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	37,861,007.91	1,137,327,768.62

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	404,425,600.00	403,588,452.11	837,147.9	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,425,600.00	403,588,452.11	837,147.9	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,025,600.00	402,338,452.11	687,147.9	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,607,900.00	238,125,857.05	482,042.9	99.8
210101	Үндсэн цалин	188,505,800.00	188,505,800.00	0.0	100.0
210102	Нэмэгдэл	33,625,100.00	33,180,749.05	444,350.9	98.7
210105	Гэрээт ажлын хөлс	16,477,000.00	16,439,308.00	37,692.0	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,617,200.00	32,617,200.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	22,952,800.00	22,952,800.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,416,100.00	2,416,100.00	0.0	100.0

**Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	YOMШӨ-ний даатгал	1,932,900.00	1,932,900.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	483,300.00	483,300.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,832,100.00	4,832,100.00	0.0	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,885,300.00</b>	<b>18,863,125.06</b>	<b>22,174.9</b>	<b>99.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,045,300.00	3,045,300.00	0.0	100.0
210302	Түлш, халаалт	15,840,000.00	15,817,825.06	22,174.9	99.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,465,900.00</b>	<b>38,465,170.00</b>	<b>730.0</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	3,428,300.00	3,428,300.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	23,940,300.00	23,940,280.00	20.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,137,300.00	1,136,600.00	700.0	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,360,000.00	9,359,990.00	10.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,200,000.00</b>	<b>5,200,000.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,200,000.00	5,200,000.00	0.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,623,400.00</b>	<b>26,594,100.00</b>	<b>29,300.0</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	6,990,700.00	9,300.0	99.9
210602	Тавилга	6,000,000.00	6,000,000.00	0.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	180,000.00	20,000.0	90.0
210604	Урсгал засвар	13,423,400.00	13,423,400.00	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,903,900.00</b>	<b>5,880,500.00</b>	<b>23,400.0</b>	<b>99.6</b>
210702	Дотоод албан томилолт	5,903,900.00	5,880,500.00	23,400.0	99.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,222,000.00</b>	<b>5,092,500.00</b>	<b>129,500.0</b>	<b>97.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00	1,100,000.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	218,000.00	88,500.00	129,500.0	40.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31500000.00</b>	<b>31500000.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,500,000.00	30,500,000.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1400000.00</b>	<b>1250000.00</b>	<b>150,000.0</b>	<b>89.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,400,000.00</b>	<b>1,250,000.00</b>	<b>150,000.0</b>	<b>89.3</b>

**Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,250,000.00	150,000.0	89.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	404,425,600.00	403,588,452.11	837,147.9	99.8
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	403,425,600.00	403,238,452.11	187,147.9	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	403,425,600.00	403,238,452.11	187,147.9	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	350,000.00	650,000.0	35.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	350,000.00	650,000.0	35.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19	19	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	21	21	0.0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.0	100.0
650010	Гэрээт ажилтан	4	4	0.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0.0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,854,689.00</b>	<b>55,385,995.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,854,689.00</b>	<b>55,385,995.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	21,854,689.00	55,385,995.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,854,689.00	55,385,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,854,689.00	55,385,995.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	21,854,689.00	113443545.54
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,854,689.00	113,443,545.54
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,854,689.00	113,443,545.54

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 01 дүгээр сарын 24 өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2021 оны 1-3 сар хүртэл Бөмбөгөр сумын ЗДТГ-ын дарга Б.Чулуундорж, 4-10 сар хүртэл даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Наранбат, 10-12 сар хүртэл даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тайванжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Очирбат нар зурж байна.

#### **3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Бөмбөгөр сумын ЗДТГ нь “ЗДТГ-н үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, Монгол улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 563,546.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,453.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,917.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,314.5 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,137,483.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 15,081.6 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,574.1</b>	<b>48,976.8</b>	<b>13,402.7</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	41.3	50.2	8.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	35,532.8	48,926.6	13,393.8
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,086,827.5</b>	<b>1,088,424.5</b>	<b>1,597.0</b>
Үндсэн хөрөнгө	1,780,665.3	1,893,878.8	113,213.5
Хуримтлагдсан элэгдэл	(693,837.8)	(805,454.3)	(111,616.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,122,401.6</b>	<b>1,137,401.3</b>	<b>14,999.7</b>
Өр төлбөр	72.1	127.0	54.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,122,329.5	1,137,356.2	15,026.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,122,401.6</b>	<b>1,137,483.2</b>	<b>15,081.6</b>

*/Эх сурвалж Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаас/*

Авлагын дансны 50.2 мянган төгрөг болж 8.9 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48,926.6 мянган төгрөг болж 13,393.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 20,008.6 мянга, сэлбэг хэрэгсэл 4,020.2 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Мөн аж ахуйн материалд Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлаас цаашид ашиглагдах 448.0 мянган төгрөгийн материал, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,416.0 мянган төгрөгийн гэрэлт самбар, хандиваар 7,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас, бэлэн бүтээгдэхүүнд ард иргэд аж ахуйн Аудитын код БНА-2022/59/НА-СТА-ТШЗ

нэгжээс хандив тусламжаар 21,372.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, өвс болон бусад материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,893,878.8 мянган төгрөг болж 113,213.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 26,961.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сумын Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 40,000.0 мянган төгрөгийн гэрэлтүүлэг гудамж, 19,818.4 мянган төгрөгийн худаг, 20,000.0 мянган төгрөгийн трансформатор, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 3,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,137,356.2 мянган төгрөг болж 15,026.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 15,026.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 506,561.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 506461.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 138,335.8 мянган төгрөгөөр бууруулж 368,225.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 36,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн цалин, нэмэгдэл урамшуулал, хангамж бараа материалын зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 404,425.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 403,425.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 403,425.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 350.0 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 403,588.5 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн санхүүжилтээс 187,147.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 403,588.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 482.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 22.2 мянга, хангамж бараа материалын зардал 22.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 29.3 мянга, дотоод албан томилолт 23.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 129.5 мянга, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал 150.0 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 113,443.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 55,386.0 мянган төгрөг зарцуулж 58,057.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс малчдад өвс хүргэх зардалд 4,165.4 мянга, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 946.2 мянга, аймгийн ХХААГ-аас оготно устгалын зардалд 9,072.0 мянга, аймгийн ГБХЗХГ-аас хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянга, нөхөн сэргээлтийн зардалд 52,232.9 мянга, тендерийн хураамж 631.6 мянга, урд оны төвлөрүүлсэн орлогоос 30,725.4 нийт 115,443.5 мянган төгрөгийн орлого төвлөрч 55,386.0 мянган төгрөгийг зарцуулж 58,057.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Н.Бүнчинсүрэн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 58 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.23 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 618,709.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 55,163.3 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос өсөж, байр ашиглалттай тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил авах зардал, томилолт зочны зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 563,504.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 51 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4 гүйлгээний 57,850.0 мянган төгрөгийн мэдээлээгүй байна. Энэ нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	2	7	2
2	Хагас жил	4	4	0	4	
3	Улирал бүр	1	4	1	3	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	59	37	
	Нийт	27	151	98	51	2

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Тайлант онд нийт 404,425.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 403,588.4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 187.2 мянган төгрөг буюу төсвийн 0.04 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 18,885.3 мянган төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 18,863.1 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

### **3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалтай” санал дүгнэлт авсан ба 30385.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 972.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 29413.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.04.23-ны өдрийн 78 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 115,725.2 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч 272.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 57,600.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй 2 зөвлөмжийг хүргүүлээ.

### 4.1 Төлбөрийн акт

1. Орон нутаг хариуцсан нягтлан бодогч Ж.Сэржмядагийн хүүхэд асарсны чөлөөтэй хугацаанд НДШ-ийг мэдээлэхдээ 01 кодоор мэдээлж даатгуулагчаас 96.6 мянган төгрөгийг илүү мэдээлж төсвөөс төлсөн байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021.11.11-ны өдрийн А/182 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.8 “Шимтгэлийн тайланд даатгуулагчийн овог, нэр, регистрийн дугаар (дахин давтагдашгүй дугаар), төрлийн код болон бусад мэдээллийг зөв оруулах”, гэсэн заалт санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Ж.Сэржмядагийн илүү мэдээлсэн нийгмийн даатгалын шимтгэлийг залруулж 96.6 мянган төгрөгийг байгууллагын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын кассын дансанд 2021.12.23-нд 53.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл гэж шилжүүлж нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлээгүй кассын үлдэгдлээр тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.1-т “ Аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Кассын үлдэгдэл 53.6 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1,250.0 мянган төгрөгийн тэтгэмж, шагнал урамшуулал олгохдоо ХАОАТ-ыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас суутган тооцоо хийж 125.0 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тус байгууллага нь 2021 онд нийт 563,504.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 51 мэдээллийг хугацаа

хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4 гүйлгээний 57,850.0 мянган төгрөгийн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

2. Тавилга эд хогшилд бүртгэлтэй 57,600.0 мянган өртөгтэй 2 ширхэг эрчим хүчний моторны үнэнд 10,000.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дансанд 2010.05.04-нд иргэн Бямбацэрэн бэлнээр тушаасан байна.

**Өгсөн зөвлөмж:** Тавилга эд хогшилд бүртгэлтэй 57,600.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг моторын үнийн тушаасан байгаа баримт материалыг ОНӨГ—аар шалгуулж хууль зүйд нийцсэн эсэхийг тогтоон, хөрөнгөөс хасах эсэх талаарх шийдвэрийг гаргуулах.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бөмбөгөр сумын ЗДТГ	5	115,725.2			3	275.2			2	115,450.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_